



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН
БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.04.22 № 3Г-1/33

танай _____-ны № _____-т

Асуудал зөвшилцөх тухай

Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ¹⁷ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001662

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ХАВСРАЛТ

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулж, 2019 оны 7 дугаар сарын 9, 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлт

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх, Монгол Улс болон Польш Улс хоорондын эдийн засгийн үр дүнтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулж, 2019 оны 7 дугаар сарын 9, 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн дагуу дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулж, 2019 оны 7 дугаар сарын 9, 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулав.

- 1) 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “2. Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан гэрээг Монгол Улсын импортлогч болон Бүгд Найрамдах Польш Улсад байршилтай үйлдвэрлэгч (цаашид “Польшийн үйлдвэрлэгч” гэх) нарын хооронд 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө байгуулна.” гэж өөрчлөх;
- 2) 8 дугаар зүйлийг “Тус хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй гэрээний дагуу Польшийн гүйцэтгэгчид төлөх төлбөрийг тус Хэлэлцээр дэх гэрээ хэрэгжүүлж дуусах хүртэл хүчинтэй байх нөхцөл заалтын дагуу хийгдэх бөгөөд тус гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 8 жилийн дотор хийж гүйцэтгэнэ.” гэж өөрчлөх;
- 3) Зээлийн хүрээнд санхүүжүүлэх төслийг тодорхойлсон шинэчлэгдсэн хавсралтыг энэхүү хавсралтад нэмнэ.



2 дугаар зүйл

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу батлагдах бөгөөд энэ тухайгаа ноот бичиг солилцон баталгаажуулна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдөр хүчин төгөлдөр болно.


Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулж, 2019 оны 7 дугаар сарын 9, 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн болон энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хүлээсэн бүх үүрэг биелэгдэх хүртэл хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

.....хотнооөдөр монгол, польш, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Эх бичвэрүүдийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эхийг баримтална.

Монгол Улсын Засгийн
газрыг төлөөлж


Бүгд Найрамдах Польш Улсын
Засгийн газрыг төлөөлж



Хавсралт

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулж, 2019 оны 7 дугаар сарын 9, 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдөр болон энэхүү хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн дагуу санхүүжүүлэх төсөл:

№	Төсөл арга хэмжээ	Дүн /сая евро/
1	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төсөл 1.1 Баян-Өлгий аймаг 1.2 Говьсүмбэр аймаг 1.3 Дорнод аймаг 1.4 Увс аймаг 1.5 Завхан аймаг	27.35
2	“Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх” төсөл	3.0
3	“Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт II шатлалын эмнэлэг” төсөл	6.5
4	“Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төсөл	9.0
5	“Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх” төсөл	4.15
	Нийт дүн	50.0



Annex

to the Agreement between the Government of Mongolia and the Government of the Republic of Poland and on extending a tied aid credit, done at Ulaanbaatar on May 9, 2017, amended by Annex done at Ulaanbaatar on July 9, 2019 and Annex done at Ulaanbaatar on March 11, 2021

The Government of Mongolia and the Government of the Republic of Poland, henceforth called the "Contracting Parties", with a view to continue the constructive economic co-operation between Mongolia and the Republic of Poland, in accordance with Article 13 of the Agreement between the Government of Mongolia and the Government of the Republic of Poland on extending a tied aid credit, done at Ulaanbaatar on May 9, 2017, amended by Annex done at Ulaanbaatar on July 9, 2019 and Annex done at Ulaanbaatar on March 11, 2021, have agreed as follows:

Article 1

The Agreement between the Government of Mongolia and the Government of the Republic of Poland extending a tied aid credit, done at Ulaanbaatar on May 9, 2017, amended by Annex done at Ulaanbaatar on July 9, 2019 and Annex done at Ulaanbaatar on March 11, 2021, shall be amended as follows:

- 1) Article 3 paragraph 2 shall be amended to read: "2. The contracts referred to in Article 1 shall be concluded by entrepreneurs having their seats in the Republic of Poland, henceforth called "Polish entrepreneurs", and the importers from Mongolia not later than on December 31, 2026."
- 2) Article 8 shall be amended to read:

"Article 8

Payments to the Polish entrepreneurs resulting from the contracts realised under this Agreement shall be made under the stipulations of the Agreement until the date of the execution of these contracts, according to the terms of the relevant contracts, but for no longer than 8 (eight) years from the date the contract enters into force.";

- 3) the enclosure which specifies the projects to be financed under the Credit shall be amended, in wording of the enclosure to this Annex.

Article 2

This Annex shall be subject to approval in accordance with internal law of each of the Contracting Parties, which shall be confirmed by exchange of notes. This Annex shall come into force on the date of the receipt of the later note. This Annex remains valid until all obligations of both Contracting Parties arising from the Agreement between the Government of Mongolia and the Government of the the Republic of Poland on extending a tied aid credit, done at Ulaanbaatar on May 9, 2017, amended by Annex done at Ulaanbaatar on July 9, 2019, Annex done at Ulaanbaatar on March 11, 2021, and this Annex are fulfilled.

Done at on in two originals, each in the Mongolian, Polish, and English languages, all texts being equally authentic. In case of any divergences of interpretation of the Annex, the English text shall prevail.

**For the Government
of Mongolia**

**For the Government
of the Republic of Poland**

Enclosure

Projects to be financed under the Agreement between the Government of the Republic of Poland and the Government of Mongolia on extending a tied aid credit, done at Ulaanbaatar on May 9, 2017, amended by Annex done at Ulaanbaatar on July 9, 2019, Annex done at Ulaanbaatar on March 11, 2021 and this Annex:

No	Project name	Amount /million euro/
1	Enlargement construction and design development for the wastewater treatment plants of the provinces Bayan-Ulgii, Zavkhan, Uvs, Dornod and Gobisumber	27.35
2	Upgrading fire-fighting equipment and technologies	3.0
3	Disaster times mobile hospital (2 sets)	6.5
4	Establishing a factory for solid waste in Erdenet city, management improvement project for waste disposal	9.0
5	Fully equipped vehicles to provide mobile medical services in provinces	4.15
	Total	50.0

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

Энэхүү 50.0 сая еврогийн нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 25 дугаар тогтоол, 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 94 дүгээр тогтоол, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 113 дугаар тогтоолын дагуу дараах 5 төслийг хэрэгжүүлэхээр тогтсон:

- 1.Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл – 27.35 сая евро;
- 2.Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл – 3 сая евро;
- 3.Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт эмнэлэг төсөл – 6.5 сая евро;
- 4.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл – 9 сая евро;
- 5.Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх төсөл – 4.15 сая евро.

Өнөөдрийн байдлаар эдгээр 5 төслөөс 3 төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан бөгөөд “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл” 84.5 хувь, “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл” 90 хувийн хэрэгжилттэй байна. Тухайлбал:

1.Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /27.35 сая евро/:

Бүгд Найрамдах Польш Улс (цаашид “БНПУ” гэх)-ын Засгийн газартай байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс, Дорнод аймгуудад хоногт 3000м³-5000м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 17.5 сая еврогоор барихаар анх төлөвлөсөн ба Дорнод аймаг болон бусад аймгуудын барилгын нэмэлт ажлыг санхүүжүүлэх хүрээнд Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 113 дугаар тогтоолоор төслийн нийт санхүүжилтийг 27.35 евро болгон нэмэгдүүлсэн.

Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг БНПУ-ын “Smart waste technologies” компанитай 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажил 96-98 хувьтай, Улсын комисс ажилласан, туршилт тохируулгын ажил хийгдэж байна.

Харин Дорнод аймагт хоногт 5000 м³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2021 оны 07 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан боловч аймгийн хүн амын эрчимтэй өсөлт болон бусад хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах шаардлагын дагуу цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг 10000 м³ болгон нэмэгдүүлж, анхны зураг төсөв, технологийг өөрчлөн, эскиз зураг гаргах ажлыг 2024 онд эхлүүлсэн бөгөөд холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, магадлалын дүгнэлтийг гаргуулж, 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр зураг төсөв эцэслэн батлагдсан байна.

Дорнод аймагт шинээр барих бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр төсөвт өртөг өссөн бөгөөд уг санхүүжилтийг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 113 дугаар тогтоолоор тус нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжээгүй “Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл”-ийн 7.8 сая еврог шилжүүлэн төслийн нийт санхүүжилтийн дүнг 11.0 сая евро болгон шийдвэрлэсэн.

Төсөвт өртөг нэмэгдсэнтэй холбоотойгоор дахин нээлттэй тендер шалгаруулах нөхцөл үүссэн бөгөөд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3.2-т заасан хугацаанд багтаж гэрээ байгуулах шаардлагатай болсон. Гэвч энэ хугацаа 2021 оны 07 дугаар сарын 24-нд дуусгавар болсон тул уг хугацааг сунгах зайлшгүй шаардлага үүссэн.

2.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл /9.0 сая евро/:

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Орхон аймагт “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор польш компанитай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан.

Ковид-19 цар тахлын улмаас тавигдсан хилийн хориг болон хөрш оронд болж буй цэргийн үйл ажиллагааны улмаас гэрээний хугацааг 2021-2024 онуудад тус бүр 1 жилээр сунгасан байна.

Төслийн хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах хүрээнд 6 төрлийн 12 машин механизм нийлүүлэх ажил бүрэн хийгдсэн ба барилга угсралтын ажил 90 хувьтай, үйлдвэрийг усаар хангах гүний худгийг гаргаж, үйлдвэрийн дэргэд цахилгааны дэд станцыг байгуулсан байна.

Одоогийн байдлаар хатуу хог боловсруулах үйлдвэр, зам, тоног төхөөрөмжийг улсын комисст хүлээлгэн өгөх, сургалт, туршилт тохируулгын ажил хүлээгдэж байна. Төсөл нь 9.0 сая еврогийн төсөвтэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд 8.1 сая еврогийн санхүүжилт олгосон ба үлдсэн 0.9 сая еврогийн төлбөрийг түлхүүр гардуулах гэрээний дагуу барилгыг улсын комисст хүлээлгэн өгч, ажилчдын сургалт, туршилт тохируулга хийгдсэний дараа олгох юм.

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд тус хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш санхүүжилтийг 5 жилийн дотор олгож дуусахаар заасан. Тус төслийн түлхүүр гардуулах гэрээ 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд санхүүжих эцсийн хугацаа 2025 оны 02 дугаар сарын 20-оор дуусгавар болсон тул төслийн үлдэгдэл 0.9 сая еврог санхүүжүүлэхийн тулд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан хугацааг өөрчлөх шаардлага үүсээд байна

Иймд Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн хүрээнд баригдах Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн худалдан авах ажиллагааг зарлаж, гэрээ байгуулахад нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т нэмэлт, өөрчлөлт оруулан гэрээг **2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах**, тус байгууламж болон Орхон аймгийн хатуу хог боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл удааширч байгаатай холбогдуулан, барилга байгууламжийг дуусгаж, эцсийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8-р зүйлд заасан санхүүжилтийн эцсийн хугацааг **3 жилээр сунгах**, мөн Засгийн газрын тогтоолоор шинэчлэн хуваарилсан “Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн 50.0 сая еврогийн хуваарилалтыг баталгаажуулах нэмэлт, өөрчлөлтийн хавсралтын төслийг танилцуулж байна.

Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь зээлийн гэрээний нийт дүн, хүү, эргэн төлөгдөх хугацаа зэрэгт өөрчлөлт оруулахгүй бөгөөд Польшийн талтай эцэслэн тохиролцсон болно.

---oOo---

**УЛААНБААТАР ХОТНОО 2017 ОНЫ 05 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР
БАЙГУУЛЖ, 2019 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09 БОЛОН 2021 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 11-НИЙ ӨДӨР ХАВСРАЛТААР НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛАХ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улс (цаашид “БНПУ” гэх)-ын Засгийн газар хооронд 50.0 сая еврогийн нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

1. НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХУГАЦАА СУНГАСАН ТАЛААР

Хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 25 дугаар тогтоолоор хөдөө аж ахуй, дэд бүтэц, байгаль орчны хамгаалал, эрүүл мэндийн салбарт 6 төслийг хэрэгжүүлэхээр тогтсон.

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын импортлогч болон БНПУ-ын үйлдвэрлэгч нар тус зээлээр санхүүжүүлэх төслүүдийн гэрээг нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн дотор буюу **2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс өмнө байгуулахаар заасан** бөгөөд тус хугацаанд Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл, Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт эмнэлэг төслүүдийн тусгайлсан гэрээг байгуулж, төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

Үлдсэн 4 төслийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын импортлогч болон БНПУ-ын үйлдвэрлэгч нарын хороонд гэрээ байгуулах хугацааг 1 жилээр буюу **2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүртэл сунгах шаардлагатай** болсны дагуу хугацаа сунгах тухай нэмэлт, өөрчлөлт оруулах хавсралтыг Польшийн талтай тохиролцсон. БНПУ-ын талаас хавсралтад гарын үсэг зурах үйл ажиллагаа нь удаашралтай байсан бөгөөд гарын үсэг зурсан хавсралтыг Сангийн яаманд **2019 оны 07 дугаар сарын 09-ний өдөр ирүүлснээр Сангийн сайд хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах хавсралтад гарын үсэг зурж**, Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр соёрхон батлуулсан. Хугацаа сунгах тухай хавсралтыг байгуулах явц удааширсантай холбоотойгоор нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийг сунгасан хугацаанд зөвхөн “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийн тусгайлсан гэрээг байгуулсан.

Үлдсэн 3 төслийг хэрэгжүүлэхийн тулд хугацааг дахин сунгах тухай Хавсралт 2-ыг байгуулахаар польшийн талтай тохиролцож, төслийг боловсруулан **Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т заасны дагуу** Хавсралт 2-ыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтад **2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр гарын үсэг зурсан**. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл болон Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглолгдсон автомашин ханган нийлүүлэх төслийн тендерийг зохион байгуулж,

төслийн гэрээг хэлэлцээрийн хугацаа буюу **2021 оны 07 дугаар сарын 24-өөс өмнө** амжилттай байгуулсан.

Харин тус зээлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төслийн тендер 2 удаа амжилтгүй болсноор польшийн талтай тохиролцон төсөлд хуваарилагдсан 10.0 сая еврог Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 94 дүгээр тогтоол, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 113 дугаар тогтоолоор бусад төслийн санхүүжилтэд хуваарилж, төслүүдийн санхүүжилтийн хэмжээ дараах байдалтай болсон. Үүнд:

1.Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл – 27.35 сая евро;

2.Гал түймэртэй тэмцэх техник тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл – 3.0 сая евро;

3.Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт эмнэлэг төсөл – 6.5 сая евро;

4.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл – 9.0 сая евро;

5.Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх төсөл – 4.15 сая евро.

Өнөөдрийн байдлаар нийт 5 төслөөс 3 төсөл амжилттай хэрэгжиж, бүрэн дууссан бөгөөд Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл 84.5 хувь, Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл 80 хувийн хэрэгжилттэй тус тус байна.

2. НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХУГАЦААГ СУНГАЖ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА

2.1.Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /27.35 сая евро/

Засгийн газар хоорондын Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс, Дорнод аймгуудад хоногт 3000м³-5000м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барих ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, төслийн ажлыг эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэл 97-98 хувьтай байгаа ба Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн төслийн гүйцэтгэл 23 хувьтай байна.

Төслийн хүрээнд анх Дорнод аймагт баригдах ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар 5000м³/хон хүчин чадалтай байхаар 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн №2020/75 тоот ажлын даалгавар батлагдсанаар “Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих түлхүүр гардуулах нөхцөлтэй” 3.2 сая еврогийн 24 сарын хугацаатай, №2021/220 тоот гэрээг БНПУ-ын “Мелиорекс” ХХК-тай 2021 оны 07 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Гэрээг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн №2021/338 тоот нэмэлт, өөрчлөлтөөр 2024.12.31 хүртэл 1 удаа сунгасан.

Гэвч Дорнод аймгийн хүн амын эрчимтэй өсөлт болон бусад хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах шаардлагын дагуу уг цэвэрлэх байгууламжийн 5000м³/хон хүчин чадлыг 10,000м³/хон болгон нэмэгдүүлж 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр № 2022/39 тоот ажлын даалгаврыг баталсан. Уг ажлын даалгаварт механик болон биологи цэвэрлэгээний байгууламж, хотын насос станцын өргөтгөл, автоматжуулалт, гэрэлтүүлэг, дотор холбоо, автоматикийн угсралтын ажил, туршилт тохируулга хийгдэхээр зураг төслийн ажлын даалгавар хийгдсэн.

Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг 10000 м³/хон болгон нэмэгдүүлж, анхны зураг төсөв, технологийг өөрчлөн, эскиз зураг гаргах ажлыг 2024 онд эхлүүлсэн бөгөөд холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, магадлалын дүгнэлтийг гаргуулж, 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр зураг төсөв эцэслэн батлагдсан байна.

Дорнод аймагт шинээр барих бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр төсөвт өртөг өссөн бөгөөд уг санхүүжилтийг Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 113 дугаар тогтоолоор тус зээлээс санхүүжих байсан боловч хэрэгжээгүй “Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл”-ийн 7.8 сая еврог шилжүүлэн төслийн нийт санхүүжилтийн дүнг 11.0 сая евро болгон шийдвэрлэсэн.

Төсөвт өртөг, барилга, байгууламжийн хүчин чадал нэмэгдсэнтэй холбоотойгоор дахин нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулах нөхцөл үүссэн бөгөөд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3.2-т заасан хугацаанд багтаж гэрээ байгуулах шаардлагатай болсон. Гэвч энэ хугацаа нь 2021 оны 07 дугаар сарын 24-нд дуусгавар болсон байна.

Иймд, нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3.2-т заасан хугацааг сунгах зайлшгүй шаардлага үүссэн болно. Мөн уг ажлыг санхүүжүүлэхийн тулд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан 5 жилийн хугацааг 8 жил болгон нэмэгдүүлэх шаардлага үүссэн.

2.2.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл /9.0 сая евро/

Монгол Улс, БНПУ-ын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Орхон аймагт “Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор польш компанитай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан.

Ковид-19 цар тахлын улмаас тавигдсан хилийн хориг болон хөрш оронд болж буй цэргийн үйл ажиллагааны улмаас гэрээний хугацааг 2021- 2024 онуудад тус бүр 1 жилээр сунгасан байна.

Төслийн хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах хүрээнд 6 төрлийн 12 машин механизм нийлүүлэх ажил бүрэн хийгдсэн ба барилга угсралтын ажил 90 хувьтай, үйлдвэрийг усаар хангах гүний худгийг гаргаж, үйлдвэрийн дэргэд цахилгааны дэд станцыг байгуулсан байна.

Өнөөдрийн байдлаар хатуу хог боловсруулах үйлдвэр, зам, тоног төхөөрөмжийг улсын комисст хүлээлгэн өгөх, сургалт, туршилт тохируулгын ажил хүлээгдэж байна. Төсөл нь 9.0 сая еврогийн төсөвтэй хэрэгжиж байгаа бөгөөд 8.1 сая еврогийн санхүүжилт олгосон ба үлдсэн 0.9 сая еврогийн төлбөрийг түлхүүр гардуулах гэрээний дагуу барилгыг улсын комисст хүлээлгэн өгч, ажилчдын сургалт, туршилт тохируулга хийгдсэний дараа олгох юм.

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд тус хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш санхүүжилтийг 5 жилийн дотор олгож дуусахаар заасан боловч тус төслийн түлхүүр гардуулах гэрээ 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд санхүүжих эцсийн хугацаа 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөр дуусгавар болсон байна.

Иймд төслийн үлдэгдэл 0.9 сая еврог санхүүжүүлэхийн тулд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан 5 жилийн хугацааг нэмэгдүүлэх шаардлага мөн үүссэн болно.

3. ПОЛЬШИЙН ТАЛТАЙ ТОХИРОЛЦСОН БАЙДАЛ

Хоёр улсын Засгийн газар хоорондын “Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийг амжилттай хэрэгжүүлж дуусгах, дээрх нөхцөлт байдлыг үнэлсний үндсэн дээр Польшийн талтай дараах нэмэлт, өөрчлөлтийг хийхээр тохиролцсон. Үүнд:

1. Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн хүрээнд баригдах Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн худалдан авах ажиллагааг зарлаж, гэрээ байгуулахад Зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т нэмэлт, өөрчлөлт оруулан гэрээг **2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах;**

2. Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламж болон Орхон аймгийн хатуу хог боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг дуусгаж, эцсийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан санхүүжилтийн эцсийн хугацааг 5 жил гэснийг 3 жилээр нэмэгдүүлж **8 жил болгох;**

3. Засгийн газрын тогтоолоор зээлийн эх үүсвэрийг шинэчлэн хуваарилсан “Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн 50.0 сая еврогийн хуваарилалтыг баталгаажуулан, хавсралтаар эцэслэн баталгаажуулах.

Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь зээлийн гэрээний нийт дүн, хүү, эргэн төлөгдөх хугацаа зэрэгт өөрчлөлт оруулахгүй бөгөөд Польшийн талтай эцэслэн тохиролцсон болно.

4. ЗЭЭЛИЙН ГОЛ НӨХЦӨЛ, ХҮҮ, ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 1-д заасны дагуу зээлийн гол нөхцөл нь дараах байдалтай бөгөөд Зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2, 8 дүгээр зүйлд оруулах нэмэлт, өөрчлөлт нь зээлийн хэлэлцээрийн гол нөхцөлийг хөндөөгүй болно.

Зээлийн нөхцөл:

Зээлийн хэмжээ:

50.0 сая евро;

Зээлийн хүү (жилийн):

0.15 хувь;

Хугацаа:

28 жил;

Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 5 жил;

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 6.1, 6.2-т заасны дагуу зээлийн ашиглалт бүрээр хүү, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг тооцож байгаа бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар нийт 5 төслийн хэмжээнд үндсэн төлбөрт 2.6 тэрбум, хүүгийн төлбөрт 719.1 сая төгрөгийн төлбөрийг төлсөн байна.

Зээлийн хэлэлцээрийн дагуу ашиглалт гарсан үед хүү төлөгдөх бөгөөд зээлийн хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2, 8 дүгээр зүйлд заасан хугацааг сунгахад ямар нэгэн хөрөнгө баталгаажуулсны төлбөр болон хүү төлөгдөхгүй болно.

5.МОНГОЛ УЛСЫН БОДЛОГЫН ДЭМЖЛЭГ

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-т оруулах нэмэлт, өөрчлөлт нь дараах хууль, бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцэж байна.

-“Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хөнгөлөлтийн түвшин нь 51.8 хувь бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 23.1.3-т заасны дагуу нэн хөнгөлөлттэй зээл тул тус хуулийн 23.3, 18.5.1-18.5.4, 18.5.7 дахь заалтын шаардлагыг бүрэн хангаж байна.

-Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-ийн 2.6-д заасан “гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр гэрээ байгуулсан төслүүдийн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх үндэслэл болно.

Зээлийн хүрээнд хэрэгжиж буй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл” нь дараах бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан буюу нийцсэн болно.

-“Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Хүнд ээлтэй амьдрах орчин зорилтын 2.5.11-д “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор өргөтгөж, шинэчилнэ”;

-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.3.4-т “Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ”.

Харин “Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл” нь дараах бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан буюу нийцсэн болно.
Үүнд:

-“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 6.4-т “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна. ... 5 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах,

боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулан хог хаягдлын дахин боловсруулах хэмжээг нэмэгдүүлнэ” зэрэг болно.

6.ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСНЫ АЧ ХОЛБОГДОЛ БОЛОН ОРУУЛААГҮЙГЭЭС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР, ҮР НӨЛӨӨ

Хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулснаар дараах ач холбогдолтой байна. Үүнд:

1. Засгийн газар хооронд байгуулсан нэн хөнгөлөлттэй зээлийг бүрэн ашигласнаар Монгол Улсын хувьд нийгмийн болон эдийн засгийн хувьд үр ашигтай.

2. Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн тухайд: тус аймгийн төв нь Улаанбаатар хотоос 670 км зайтай, 281 км² нутаг дэвсгэртэй, 47.1 мянган хүн ам, 13 мянган өрхтэй бөгөөд Дорнод аймгийн хүн амын 50% нь амьдардаг. Аймгийн төвийн хүн ам жилд дундажаар 1%-аар өсдөг бөгөөд инженерийн төвлөрсөн хангамжтай нийтийн орон сууцны барилгуудад нийт өрхийн 38% буюу 4.9 мянган өрх амьдарч, жилд орон сууцжуулалт 20-100 орон сууцаар нэмэгддэг байна. Тус аймаг 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөндөө орон сууцанд амьдардаг аймгийн төвийн хүн амыг 70%-д хүргэхээр тусгасан байна. Шинээр ашиглалтад орох 10000м³/хон хүчин чадалтай, орчин үеийн цэвэрлэх байгууламж нь аймгийн төвийн 1.3 сая м² шинэ барилгажилтыг холбож, бохир ус цэвэрлэх боломжийг бүрдүүлэх юм.

3. “Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийн тухайд: Эрдэнэт хотын хог хаягдал, хүрээлэн буй орчны бохирдлын асуудлыг шийдэж, хог хаягдлыг ангилан ялгаж, голчлон гарч байгаа хогийг дахин ашиглаж, дахин боловсруулах жижиг үйлдвэрийг байгуулснаар ажлын байр нэмэгдэж, эх үүсвэрээс гарах хогны хэмжээ 10-20% буурна. Мөн байгальд булшлах хог хаягдлын хэмжээ 30-50%-аар багасаж, агаар, ус, хөрсний бохирдол буурснаар эрүүл, аюулгүй, цэвэр орчин бий болно.

Хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулаагүйгээс дараах эрсдэл үүсэхээр байна. Үүнд:

1.Засгийн газар хооронд байгуулсан нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн хүрээнд хэрэгжиж буй “Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн гэрээний хүрээнд 10.1 сая, “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийн үлдэгдэл санхүүжилт болох 0.9 сая евро, нийт 11.0 сая еврог ашиглаж чадахгүйд хүрнэ.

2.Дээрх ашиглагдаагүй 11.0 сая евро буюу 46.4 тэрбум төгрөгийг төслүүдийг бүрэн дуусгахын тулд улсын төсөвт тусгах шаардлага бий болж, улсын төсөвт дарамт учруулна.

3.Улсын төсөвт 46.4 тэрбум төгрөгийг тусгаснаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжих боломжтой байсан бусад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хязгаарлана.

4.Дээрх 46.4 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах асуудлыг Улсын Их Хурлаар эцэслэн батлах хүртэл барилга байгууламж ашиглалтад орох хугацаа удаашрах магадлалтай байна.

---o0o---